

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

ГАРЧИГ

1. Ерөнхий зүйл
2. Монгол Улсын харилцаа холбооны дугаарлалтын багц томъёолол
3. Харилцаа холбооны дугаарлалтын төлөвлөлт
 - 3.1 Улсын дугаар
 - 3.2 Угтвар дугаарлалт
 - 3.2.1 Олон улсын гарцын угтвар дугаарлалт
 - 3.2.2 Дотоод гарцын угтвар дугаарлалт
 - 3.3 Тусгай дугаарлалт
 - 3.3.1 Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаарлалт
 - 3.3.2 Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт /Toll free/
 - 3.3.3 Мессежний тусгай дугаарлалт
 - 3.3.4 Олон Улсын Интернет телефон ярианы үйлчилгээнд зориулан ашиглах угтвар тусгай дугаарлалт
 - 3.3.5 Хэрэглэгчийн тарифт үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаар (Local Rate Service)
 - 3.3.6 Төлбөртэй үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаар (Premium Rate Service)
 - 3.4 Суурин холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт
 - 3.5 Интернет протоколд суурилсан ярианы үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт
 - 3.6 Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт

Хавсралт 1. Харилцаа холбооны үйлчилгээний дугаарлалтын ерөнхий томъёолол

Хавсралт 2. Нэр томъёоны тодорхойлолт

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Дугаарлалт нь хязгаарлагдмал нөөцтэй тул Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид Зохицуулах хороо гэх) нь Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө (цаашид дугаарлалтын төлөвлөгөө гэх)-нд тусгагдсан дугаар, дугаарлалтыг үр ашигтай хуваарилах зарчим баримтлан хэрэгжилтийг хангуулна.
- 1.2 Дугаарлалтын төлөвлөгөөг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээ эрхлэгчид мөрдлөг болгоно. Үйлчилгээ эрхлэгч нь энэхүү төлөвлөгөөг үндэслэн өөрийн сүлжээний дугаарлалтын төлөвлөгөөг гаргах бөгөөд Зохицуулах хороонд мэдээлэх үүрэгтэй.
- 1.3 Зохицуулах хороо нь дугаарлалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт, тодотгол оруулах талаар саналыг гаргаж болно.
- 1.4 Зохицуулах хороо нь дугаарлалтын төлөвлөгөөг Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ) болон гадаад орнуудын зохицуулах байгууллагуудад мэдээлэх үүргийг хүлээнэ.
- 1.5 Зохицуулах хороо нь дугаарлалтын хуваарилалт, ашиглалтад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулалтын арга хэмжээ авна. Зохицуулалтын арга хэмжээг дугаарлалтын журам, бусад журмуудаар зохицуулна.
- 1.6 Дугаарлалтын төлөвлөгөө нь 20.. оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 1.7 Монгол Улсын “Цахилгаан холбооны сүлжээний дугаарлалтын формат, түүнд тавих ерөнхий шаардлага” стандарт, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын E.164 болон холбогдох зөвлөмжүүдийг мөрдлөг болгоно.
- 1.8 Дугаарлалтын төлөвлөгөөг техник технологийн хөгжлийн дэвшлийг нэвтрүүлэх, харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөнийг дэмжих, үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах зорилгоор тухай бүрд өөрчилж болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТЫН БАГЦЫН ТОМЬЁОЛОЛ

Хүснэгт 1

Эхлэх дугаар	Зориулалт	Тайлбар
00х	<ul style="list-style-type: none"> Олон улсын гарцын угтвар дугаарлалт 	
0х	<ul style="list-style-type: none"> Дотоод гарцын угтвар дугаарлалт 	Энэ угтвар дугаарлалтын ард газарзүйн бүсийн дугаарлалтууд илэрхийлэгдэнэ.
1	<ul style="list-style-type: none"> Тусгай дугаарлалт 	
2	<ul style="list-style-type: none"> Суурин холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт 	
3	<ul style="list-style-type: none"> Нөөц 	
4	<ul style="list-style-type: none"> Нөөц 	
5	<ul style="list-style-type: none"> Нөөц 	
6	<ul style="list-style-type: none"> Үүрэн холбоо, зүйлсийн интернэт, дата үйлчилгээнүүдэд ашиглагдах дугаарлалт 	
7	<ul style="list-style-type: none"> Интернэт протоколд суурилсан ярианы үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт 	
8	<ul style="list-style-type: none"> Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт 	
9	<ul style="list-style-type: none"> Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт 	

ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ ДУГААРЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

3.1 Улсын дугаар¹

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээнд ашиглагдах “Улсын угтвар дугаар”-ыг “976”-гаар тогтоож өгсөн бөгөөд “Улсын угтвар дугаар” нь олон улсын орох ярианы үйлчилгээнд ашиглагдана.

Томьёолол 1

Улсын нэр	Улсын дугаар
Монгол Улс	976

3.2 Угтвар дугаарлалт

Угтвар дугаарлалт гэдэг нь хоёр болон гурван цифрийн агууламж бүхий газарзүйн бүсийн болон олон улсын гарцад ашиглагдах угтвар дугаарлалтыг хэлнэ.

¹ Монгол Улсад олгогдсон “Улсын угтвар дугаар” нь олон улсын цахилгаан холбооны байгууллагаас “Changes in the 1968 CCITT White Book... the list was then titled Recommendation E.161 / Q.11. Changes listed in the order of country code” заасны дагуу олгогдсон.

Томьёолол 2

Угтвар дугаарлалтын төрөл	Угтвар дугаарын багц
Олон улсын гарцын угтвар дугаарлалт	00х
Дотоод гарцын угтвар дугаарлалт	0х

3.2.1 Олон улсын гарцын угтвар дугаарлалт

“Олон улсын гарцын угтвар дугаарлалт” гэдэг нь олон улсын гарах ярианы үйлчилгээнд ашиглагдах 00-ээр эхэлсэн 3 орон бүхий угтвар дугаарлалтын илэрхийлэл байна.

Томьёолол 3

Олон улсын гарцын угтвар дугаарлалт
Гурван цифр бүхий дугаарлалт
00х

3.2.2 Дотоод гарцын угтвар дугаарлалт

“Дотоод гарцын угтвар дугаарлалт” гэдэг нь Монгол Улсын хэмжээнд сүлжээ эсвэл үйлчилгээний ялгаатай төрлүүдийг сонгох боломж олгох 2 оронгийн цифрээр илэрхийлэгдэх, суурин холбооны сүлжээнд ашиглагдах дугаарлалт байна.

Томьёолол 4

Дотоод гарцын угтвар дугаарлалт
Хоёр цифр бүхий дугаарлалт
0х

3.3 Тусгай дугаарлалт

Тусгай дугаарлалт нь яаралтай тусламжийн болон нэмэлт үйлчилгээ, интернэтийн үйлчилгээнд зориулагдсан нэгээр эхэлсэн 3-аас 8 оронгийн цифрээр илэрхийлэгдэх тусгай дугаарлалтын багц байна.

Хүснэгт 2

Тусгай дугаар ашиглах үйлчилгээний төрөл	Ашиглагдах тусгай дугаарын багц
Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаарлалт	10х, 11х,
Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт /Toll free/	Хувилбар 1: 111х Хувилбар 2: 111х,120х
Мессежний тусгай дугаарлалт	13-xxxx 14-xxxx 15-xxxx
Олон Улсын Интернэт телефон ярианы үйлчилгээнд зориулсан угтвар тусгай дугаарлалт	16-xx
Хэрэглэгчийн тарифт үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт	1-800-xxxx Local RateService
Төлбөртэй үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт	1-900-xxxx Premium Rate Service

3.3.1 Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаарлалт

Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаарлалт нь гоц халдварт, түргэн тусламж, онцгой байдал, гамшгийн, гал түймрийн, цагдаагийн шуурхай болон нийгэмд үүсэх сөрөг үзэгдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх дуудлагын үйлчилгээнд хэрэглэгчид тухайн орон нутгийн цахилгаан холбооны сүлжээнээс үнэ төлбөргүй холбогдох хязгаарлагдмал нөөц бүхий 3 цифрээс бүрдсэн багц дугаарууд байна.

Томьёолол 6

Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаарлалт
10х, 11х

3.3.2 Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт /Toll free/

Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт нь төрийн үйлчилгээний байгууллагуудын талаар гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах дуудлагын үйлчилгээнд хэрэглэгчид харилцаа холбооны сүлжээнээс үнэ төлбөргүй холбогдох хязгаарлагдмал нөөц бүхий 4 цифрээс бүрдсэн дугаарлалууд байна.

Томьёолол 7

Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт /Toll free/
11-1х

3.3.3 Мессежний тусгай дугаарлалт

Мессежний тусгай дугаарлалт нь бүх төрлийн мэдээ, мэдээллийг хэрэглэгчид мессежээр хүргэх, хүлээн авах зориулалтаар ашиглагдах 6 цифрийн бүрдэл бүхий багц дугаарлалт байна.²

Томьёолол 8

Мессежний тусгай дугаарлалт
Зургаан цифр бүхий тусгай дугаар
13-xxxx, 14-xxxx болон 15-xxxx

3.3.4 Олон Улсын интернэт телефон ярианы үйлчилгээнд зориулан ашиглах угтвар тусгай дугаарлалт

Олон Улсын интернэт телефон ярианы үйлчилгээнд зориулсан угтвар тусгай дугаарлалт нь хэрэглэгч олон улсын ярианы үйлчилгээнд хандалт хийхдээ холболтын чиглэлийг интернэт протоколд суурилсан гейтвэй ашигласан олон улсын ярианы үйлчилгээ эрхлэгчид рүү чиглүүлэх 4 цифр бүхий багц дугаарлалт юм.³

²Мессежид суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээнд ашиглах тусгай дугаарлалт нь үүрэн холбооны сүлжээний хэрэглэгчдэд бүх төрлийн мэдээллийг хүргэх зориулалтаар мессеж илгээх (mobile terminated), хэрэглэгчийг баталгаажуулах, санал авах зориулалтаар мессеж хүлээн авах (mobile originated) нэмэлт үйлчилгээнд зориулагдсан болно.

³ Олон Улсын интернэт телефон ярианы үйлчилгээнд зориулсан угтвар тусгай дугаарлалтыг “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх нөхцөл шаардлага”-ыг хангасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгогдоно.

Олон Улсын интернэт телефон ярианы үйлчилгээний зориулалт бүхий угтвар тусгай дугаарлалт	
Дөрвөн цифр бүхий тусгай дугаар	
16-хх	

3.3.5 Хэрэглэгчийн тарифт үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт (Local Rate Service)

Бүх төрлийн мэдээ, мэдээллийг телефон утсаар хэрэглэгчийн хэрэглэгчийн тарифаар хүргэх, хүлээн авах зориулалт бүхий (Local Rate Service) үйлчилгээний тусгай дугаарлалт нь 1-800-xxxx гэсэн багц дугаарлалт байна.⁴

Хэрэглэгчийн тарифт үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт (Local Rate Service)	
Үйлчилгээний төрлийн угтвар дугаар	Үйлчилгээний дугаар
1-800	XXXX X=0~9 илэрхийлэгдэнэ.

3.3.6 Төлбөртэй үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт (Premium Rate Service)

Бүх төрлийн мэдээ, мэдээллийг телефон утсаар төлбөртэй хүргэх, хүлээн авах зориулалт бүхий (Premium Rate Service) үйлчилгээний тусгай дугаарлалт нь 1-900-xxxx гэсэн багц дугаарлалт байна.

Төлбөртэй үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт (Premium Rate Service)	
Үйлчилгээний төрлийн угтвар дугаар	Үйлчилгээний дугаар
1-900	XXXX X=0~9 илэрхийлэгдэнэ.

3.4 Суурин холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт (Fixed line)

Суурин холбооны үйлчилгээнд 2 гэсэн цифрээр эхэлсэн дараах багц дугаарлалтууд байна.

Суурин холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт
Найман цифр бүхий дугаарлалт
2х-xxxxxx

⁴ Хэрэглэгчийн тарифт болон нэмүү өртөгт мэдээлэл лавлах үйлчилгээний зориулалттай дугаарлалт нь "Телефон ярианд суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээний нөхцөл шаардлага"-г хангасан хүсэлт гаргагчид олгогдоно. Дугаарыг мэдээлэл лавлагааны зориулалтаар зөвхөн хэрэглэгчээс нэг талын дуудлага хүлээн авах болон дуудлага хүлээн авсны дагуу хэрэглэгчтэй эргэж холбогдох зориулалтаар хоёр талын дуудлага хийх боломжтойгоор харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдох гэрээний техникийн нөхцөлийн дагуу сүлжээнд холбож болно.

3.5 Интернет протоколд суурилсан ярианы үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт

Интернет протоколд суурилсан ярианы үйлчилгээнд 7 гэсэн цифрээр эхэлсэн 8 орон бүхий дугаарлалт байна. Энэхүү дугаарлалт нь газарзүйн бүсээс үл хамаарна.

Томьёолол 13

Интернет протоколд суурилсан ярианы үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт
Найман цифр бүхий дугаарлалт
7х-xxxxxx

3.6 Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт

Үүрэн холбооны үйлчилгээнд 9, 8, 6, гэсэн цифрээр эхэлсэн 8 орон бүхий дугаарлалт байна. Энэхүү дугаарлалт нь газарзүйн бүсээс үл хамаарна.

Томьёолол 14

Үүрэн холбооны үйлчилгээнд ашиглагдах дугаарлалт
Найман цифр бүхий дугаарлалт
9х-xxxxxx
8х-xxxxxx
6х-xxxxxx

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ
ДУГААРЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТОМЬЁОЛОЛ**

Сүлжээний төрөл	Эхлэх дугаар	Хэрэглэгчийн дугаарын урт	Томьёолол
Суурин холбооны сүлжээ	2	6(8)	2х-xxxx(хх)
Үүрэн холбооны сүлжээ	6 8 9	8	6х-xxxxxx 8х-xxxxxx 9х-xxxxxx
Интернэтэд суурилсан ярианы үйлчилгээнд зориулагдсан дугаарлалт	7	8	7х-xxxxxx

Нэр томъёоны тодорхойлолт

Дугаар	“дугаар, үсэг, эсвэл тэмдэг” гэж тодорхойлсон байдаг. Энэхүү төлөвлөгөөнд “дугаар” гэсэн нэр томъёо нь IP хаяг, бие даасан системийн дугаар, домэйн нэрээс бусад бүх төрлийн мэдээлэл, харилцаа холбооны тэмдэглэгээг илэрхийлнэ.
Сүлжээний дугаарлалт	Энэхүү төлөвлөгөөнд “дугаарлалт” гэдгийг харилцаа холбооны сүлжээний дугаарын багцыг ойлгоно.
Улсын дугаар	Харилцаа холбооны хэрэглээнд зориулсан тодорхой нэг газар зүйн бүс эсвэл тухайн нэг улс, улс орнуудыг ялгах нэг, хоёр, эсвэл гурван цифрийн нийлэмж
Угтвар дугаар	Сүлжээ эсвэл үйлчилгээний ялгаатай төрлүүдийг сонгох боломж олгодог нэг ба түүнээс дээш цифрээр илэрхийлэгдэх дугаар
Хэрэглэгчийн дугаар	Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл бүхий үйлчилгээ эрхлэгчээс гэрээний хүрээнд ашиглуулахаар хэрэглэгчид олгосон дугаар. Хэрэглэгчийн дугаарын урт 6-аас 8 цифрээс бүрдэнэ.